



**НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,  
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,  
E-mail: ub@audit.mn; http://www.city.audit.mn

2014.05.14 № 397

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗРЫН ДАРГА Б.БАТЦЭНГЭЛ ТАНАА**

Санхүүгийн тайлангийн аудитын гэрчилгээ,  
аудитыг дуусгавар болгосон тухай тайланг хүргүүлж  
байна.

Хавсралт: 13 хуудас



ДЭД ДАРГА

Т.САРАНТУЯА

1110400397



## НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,  
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,  
E-mail: ub@audit.mn; http://www.city.audit.mn

2014.05.14 № 398.  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗРЫНДАРГА Б.БАТЦЭНГЭЛ  
ТАНАА

### АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн соёл, урлагийн газрын 2013 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулгад Нийслэлийн аудитын газрын санхүүгийн аудитын III баг аудит хийлээ.

#### **Үүрэг хариуцлагын талаарх мэдэгдэл**

Нийслэлийн соёл, урлагийн газар санхүүгийн тайлангаа Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ын дагуу хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэгтэй.

Санхүүгийн тайлан УСНББОУС, Сангийн Сайдаас баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналын заавар, журмын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэлийн Аудитын газрын үүрэг юм.

#### **Санал дүгнэлтийн үндэслэл**

Аудитыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Холбооноос баталсан Аудитын Олон Улсын Стандарт, Монгол Улсын Үндэсний Аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлсийг сорилын үндсэн дээр шалгадаг.

Нийслэлийн соёл, урлагийн газрын удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, баримталсан бодлого, хийсэн чухал тооцоолол, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

1110400098

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үндэслэл болсон.

Монгол Улсын төсвийн байгууллагуудад мөрдүүлж байгаа Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын заавар, журам нь УСНББОУС-ын заримтай нийцэхгүй байна. Тухайлбал, төсвийн байгууллагууд санхүүгийн тайлангаа аккруэл сууриар бус, аккруэл-мөнгө хольсон сууриар тайлагнаж байхаар журамласан нь авлага, өглөг, хөрөнгө, тайлант үеийн орлого, зардал, үр дүнгийн үзүүлэлтүүд олон улсын стандартаас зөрүүтэй илэрхийлэгдэх магадлалтай.

Сангийн яамнаас нэгэнт бүх төсөвт байгууллагуудад дээрх заавар журмыг мөрдүүлсэн учраас санхүүгийн тайланг түүнтэй нийцүүлэн аудит хийв.

### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Нийслэлийн соёл, урлагийн газрын 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс эхэлж мөн оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлангийн санхүүгийн байдлын, санхүүгийн үр дүнгийн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Сангийн сайдын тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг зөрчилгүй толилуулсан байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц. ОЧИРБАТ





НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН  
2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН

Нийслэлийн аудитын газар Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд улсын төсвөөс санхүүждэг Нийслэлийн соёл, урлагийн газрын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, олон улсын стандарт, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийв

Лавлах зүйл байвал 325093 дугаарын утаснаас лавлана уу?

Т.Сарантуяа  
Нийслэлийн аудитын газрын дэд дарга  
өрөөний утас 327744

Ц.Хосжаргал  
Санхүүгийн аудитын II албаны менежер  
өрөөний утас 315558

Ц.Саранцэцэг  
ахлах аудитор  
өрөөний утас 325093

Нийслэлийн аудитын газар

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Лхагвасүрэнгийн гудамж, Нийслэлийн  
засаг захиргааны V байр

E-mail: [ub@audit.mn](mailto:ub@audit.mn)

Вэб сайт: <http://city.audit.mn>

АУДИТЫГ ДУУСГАВАР БОЛГОСОН ТУХАЙ  
ТАЙЛАН

АГУУЛГА	ХУУДАС
• Товчилсон үгийн тайлбар.....	2
• Аудит дуусгавар болсон тухай.....	3-4
• Танилцуулга .....	5
• Санхүүгийн дотоод хяналт .....	5-6
• Гол шийдлүүд .....	6-7
• Залруулаагүй алдаа .....	8
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	8
• Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт .....	8
• Аудитын санал дүгнэлт .....	8
• Менежментийн захидлын хариу .....	9
• Аудитлагдсан санхүүгийн тайлан .....	10-18

### Товчилсон үгийн жагсаалт

НАГ	Нийслэлийн аудитын газар
НСУГ	Нийслэлийн соёл, урлагийн газар
УСНББОУС	Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

Нийслэлийн соёл, урлагийн газрын 2013 оны жилийн эцсийн  
санхүүгийн тайланд Нийслэлийн Аудитын газар аудит хийж  
дуусгавар болгосон тухай тайлан

Нийслэлийн соёл, урлагийн газрын 2013 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж дууссан тухай тайланг байгууллагын удирдлагад танилцуулж байна.

Менежментийн захидалд санхүүгийн хяналтыг сайжруулахаар өгсөн зөвлөмжийг хүргүүлж, НСУГ-аас хариу ирүүлснийг энэхүү тайланд багцлан тусгасан болно.

Байгууллагын удирдлагын анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

○ **Санхүүгийн гол хяналтууд:**

Төсвийн хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагаанд ССАЖ, НСУГ болон Нийслэл, дүүргүүдийн санхүү, төрийн сангийн хэлтсээс зохих хяналтыг хэрэгжүүлж байна. НББ-ийн тайлагналын үе шат бүрд түүнчлэн УСНББОУС болон Сангийн сайдын 2005 оны 276, 2006 оны 388, 2013 оны 73, 269 дүгээр тушаалаар баталсан журам, зааврууд, төсвийн хөрөнгийг захиран зарцуулах, хөрөнгө бэлтгэх, данс бүртгэлээс хасах, данс бүртгэлд тусгахад мөрдөж буй стандарт журам, заавар, дээд шатны удирдлагаас хэрэгжүүлж байгаа хяналтыг авч үзлээ.

○ **Санхүүгийн гол эрсдэлүүд:**

Дотоод хяналтын системийг үнэлэхэд доор дурьдсан эрсдэлүүд гарах магадлалтай байна Үүнд:

1. Аккруэл сууриар бүртгээгүй, авлага, өглөг буруу бүртгэгдэх, Э-01- /Үнэн зөв байх, иж бүрэн байх, толилуулга ба илчлэл/
2. Баримтыг бүрдүүлэлгүй орлого, зарлагыг хүлээн зөвшөөрсөн байх Э-10 /Иж бүрэн байх, Үнэн зөв байдал /
3. Дансны бичилт буруу хийсэн байх. Э-9 /толилуулга ба илчлэл/
4. Холбогдох хууль, тогтоомж зөрчсөн байх Э-14 /Үнэн зөв байдал/

Эдгээр эрсдэлүүд байгаа эсэхийг нотлох үүднээс аудитыг төлөвлөн аудитын холбогдох горимуудыг хэрэгжүүлэхэд эдгээр батламж мэдэгдэл хангахгүй зөрчил байна.

**Аудитаар илрүүлсэн гол  
зүйлсийн талаар тодруулвал:**

- Зарим байгууллага, хүмүүстэй хийсэн 14,607.4 мянган төгрөгийн тооцоог тооцооны дансаар дамжуулахгүй зардалд шууд бичсэн.

Санхүүгийн тайлангаар нийт 14,607.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 14,607.4 мянган төгрөгийн зөрчлийг залруулга хийлгэсэн тул Зөрчилгүй - санал дүгнэлт өгч байна.

Нийслэлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор 2014 оны 3 дугаар сарын 17-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурлаа.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ажилтнуудын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**Нийслэлийн Аудитын газар**

**2014.03.17.**

## Танилцуулга

Нийслэлийн соёл, урлагийн газрын 2013 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж дууссан тухай тайланг удирдлагад танилцуулж байна. Өмнө нь хүргүүлсэн Менежментийн захидалд санхүүгийн хяналтыг сайжруулахаар бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд НСУГ-ын удирдлага аудитаар илэрсэн асуудал, зөвлөмж бүрийг хүлээн зөвшөөрсөн байна.

Аудитор аудитад нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үйл ажиллагааг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдэлийг тооцож аудитыг төлөвлөж, холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай аудитын горимуудыг дансдаас түүвэрлэж хэрэгжүүлэв.

Энэхүү аудитад НСУГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хамруулсан болно.

Монгол Улсын төсвийн байгууллагуудад мөрдүүлж байгаа Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын заавар, журам нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын заримтай нийцэхгүй байна. Тухайлбал: Төсвийн байгууллагууд санхүүгийн тайлангаа аккруэл сууриар бус, аккруэл-мөнгө хольсон сууриар тайлагнаж байхаар журамласан нь авлага, өглөг, хөрөнгө, тайлант үеийн орлого, зардал, үр дүнгийн үзүүлэлтүүд олон улсын стандартаас зөрүүтэй илэрхийлэгдэх магадлалтай.

Сангийн яамнаас нэгэнт бүх төсөвт байгууллагуудад дээрхи заавар журмыг мөрдүүлсэн учраас санхүүгийн тайланг түүнтэй нийцүүлэн аудит хийв.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн сул талууд, түүнийг хэрхэн шийдвэрлэснийг дахин шалгах зэрэг ажлуудыг хийлээ.

Санхүүгийн тайлангаар гарсан зөрчлүүдийг дараах асуудлуудад хураангуйлагдсан.

### Нэг: Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

1. Аудитор санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хяналаа. Ийнхүү хянахдаа хэрэгжүүлж буй дотоод хяналтыг Нийслэлийн Аудитын газраас тооцож гаргасан санхүүгийн эрсдэл ба хяналтын байвал зохих горимтой харьцуулан шалгаж үзсэн. Үүний үр дүнд удирдлагаас зайлшгүй хэрэгжүүлэх дотоод хяналт ямар байгааг тогтоосон. Аудитор байгууллагын удирдлагад бүртгэл санхүүгийн үйл ажиллагаа, тайлагнал, дотоод хяналтад илэрсэн сул талуудыг тухай бүрд нь мэдэгдэж ажиллаа.

2. Санхүүгийн тайлангаар илэрсэн гол зөрчлүүдийг Нийслэлийн соёл, урлагийн газрын удирдлагын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Зарим байгууллага, хүмүүстэй үүссэн тооцоог тооцооны дансаар дамжуулахгүй зардалд шууд бичсэн



**Хоёр: Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд**

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Нийслэлийн соёл, урлагийн газрын санхүүгийн тайлангаар нийт 14,607.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 14,607.4 мянган төгрөгийн зөрчлийг залруулсан.

**Санхүүгийн тайланд нөлөөлөхүйц, залруулбал зохих 14,607.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.**

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан *“Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”*-ыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зарим байгууллага, хүмүүстэй үүссэн 14,607.4 мянган төгрөгийн тооцоог тооцооны дансаар дамжуулахгүй зардалд шууд бичсэн

- Дээрх зөрчлийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

**Гурав: Залруулагдаагүй алдаа**

Аудитын стандарт нь аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Эдгээр залруулагдаагүй алдаануудад энэ аудитад хамрагдсан байгууллагын удирдлага анхаарлаа хандуулж шийдвэрлэх шаардлагатай. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа байхгүй.

**Дөрөв: Тайлбар мэдүүлгийн захидал**

Нийслэлийн аудитын газар аудит хийхдээ Нийслэлийн соёл, урлагийн газрын удирдлагын зүгээс гаргасан санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлд тулгуурласан болно. Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын талаар тухайн байгууллагын санхүүгийн ажилтнуудаас тайлбар тодруулга авч бэлтгэсэн менежментийн захидлыг 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 348 тоот албан бичгээр НСУГ-т хүргүүлж, менежментийн захидалд дурдсан залруулга болон зөрчлийг хүлээн зөвшөөрсөнөө илэрхийлсэн хариуг 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 67 тоот бичгээр ирснийг хавсаргав.

**Тав: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар зөрчил гараагүй байна.


**Зургаа: Аудитын санал дүгнэлт**

Нийслэлийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайланд материаллаг хэмжээний зөрчилгүйг үндэслэн Зөрчилгүй - санал дүгнэлт өгч байна.

**Нийслэлийн Аудитын газар**

2014.03.17.


Үйлчлүүлэгчээс ирүүлсэн хариу:

  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР  
14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу-1, А.Амарын гудамж, Утас: 32-15-29,  
Факс: (976-11) 32-45-37, http://www.acoc.mn

2014.08.14 № 64  
танай 2014.08.14 -ны № 348 -т

**НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА Ц.ОЧИРБАТ ТАНАА**

Тус газрын үйл ажиллагааны 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн байдал болон илэрсэн зөрчлийн тухай бичигдсэн менежментийн захидалтай танилцлаа.  
Удирдлагын зүгээс менежментийн захидалд дурдсан зөрчлийг хүлээн зөвшөөрч байна.  
Аудитын зөвлөмжийн дагуу зөрчлийг арилгах тал дээр анхаарч ажиллах болно.

ДАРГА  Б.БАТЦЭНГЭЛ

*Т. Сэрэнтуяаг*  
*Ц. Очирбат*  
14/iii

114005000106

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН  
2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нийслэлийн соёл, урлагийн газрын  
2013 оны аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	39,601,500.00	39,920,412.00
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	196,750.00
Банкинд байгаа бэлэн мөнгө	-	196,750.00
Төгрөг	-	196,750.00
Улсын төсвийн харилцах	-	196,750.00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	39,601,500.00	39,723,662.00
Түүхий эд материал	30,447,900.00	29,901,900.00
Тусгай зориулалттай материал	30,447,900.00	29,901,900.00
Хангамжийн материал	9,153,600.00	9,821,762.00
Бичиг хэргийн материал	199,850.00	-
Аж ахуйн материал	8,953,750.00	9,371,762.00
Түлш, шатах тослох материал	-	450,000.00
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	39,601,500.00	39,920,412.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	43,588,734.02	46,770,301.74
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	43,588,734.02	46,770,301.74
Биет хөрөнгө	43,588,734.02	46,770,301.74
Барилга, байгууламж, орон сууц	19,200,000.00	16,800,000.00
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	24,000,000.00	24,000,000.00
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(4,800,000.00)	(7,200,000.00)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	16,890,540.56	13,129,227.36
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	227,668,304.20	230,427,304.20
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(210,777,763.64)	(217,298,076.84)
Тавилга, аж ахуйн эд хогшил	7,498,193.46	16,841,074.38
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	18,605,544.09	29,512,389.09
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(11,107,350.63)	(12,671,314.71)
Програм хангамж - Анхны өртөг	150,000.00	150,000.00
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(150,000.00)	(150,000.00)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	43,588,734.02	46,770,301.74
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>83,190,234.02</b>	<b>86,690,713.74</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧ</b>	-	-
Засгийн газрын сан	261,759,011.80	261,759,011.80
Хуримтлагдсан үр дүн	(179,221,172.34)	(175,720,692.62)
Өмнөх үеийн үр дүн	(179,221,172.34)	(179,221,172.34)
Тайлант үеийн үр дүн	-	3,500,479.72
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	652,394.56	652,394.56
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН</b>	83,190,234.02	86,690,713.74
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН</b>	83,190,234.02	86,690,713.74

**НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН  
2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Аудитлагдсан санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

<b>БАЛАНСЫН ЗҮЙЛ</b>	<b>Өмнөх он</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>		
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	261,697,200.00	422,401,100.00
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	261,697,200.00	422,401,100.00
Улсын төвлөрсөн төсвөөс	202,065,200.00	202,997,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	196,065,200.00	202,997,100.00
Хөрөнгийн	6,000,000.00	-
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	59,632,000.00	219,404,000.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	59,632,000.00	219,404,000.00
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	16,762,965.00	19,412,000.00
Бараа, үйлчилгээний борлуулалт	16,762,965.00	19,412,000.00
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	16,762,965.00	19,412,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	1,402,000.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	4,872,000.00	18,010,000.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	65,915.00	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,825,050.00	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	278,460,165.00	441,813,100.00
<b>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</b>	115,282,371.00	129,017,639.00
Үндсэн болон нэмэгдэл цалин	103,709,873.00	116,354,075.00
Үндсэн цалин	103,709,873.00	116,354,075.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	11,572,498.00	12,663,564.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	9,650,438.00	11,640,988.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	7,920,625.00	11,640,988.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	559,100.00	-
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	830,450.00	-
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	340,263.00	-
Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,922,060.00	1,022,576.00
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	158,607,255.08	304,498,898.28
Бараа үйлчилгээний урсгал зардал	44,480,328.08	36,122,348.28
Бусад бараа үйлчилгээний зардал	44,480,328.08	36,122,348.28
Бичиг хэргийн зардал	3,538,945.00	3,247,350.00
Тээвэр, шатахуун	6,119,540.00	6,730,000.00
Шуудан, харилцаа холбоо	2,869,698.00	3,820,971.00
Дотоод албан томилолт	400,000.00	510,000.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	42,700.00	500,000.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	-	823,350.00
Сургалт семинарын зардал	8,401,500.00	3,410,000.00
Жижиг эд хогшил худалдан авах	1,063,997.00	-
Багаж хэрэгсэл худалдан авах	1,063,997.00	-
Төлбөр хураамж, жижиг татварууд	306,925.00	1,327,300.00

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН		
Урсгал засвар	6,264,400.00	5,256,500.00
Холбооны шугам ашигласны зардал	6,000,000.00	12,600.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,472,623.08	10,484,277.28
Хөтөлбөр арга хэмжээний зардал	114,126,927.00	268,376,550.00
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	104,671,020.00	253,376,550.00
Соёл урлаг хөгжүүлэх зардал	-	220,024,000.00
Уран бүтээлийн зардал	29,823,320.00	33,352,550.00
Бусад төвлөрсөн арга хэмжээ	74,847,700.00	-
Засгийн газрын нөөц хөрөнгө /Орон нутгийн нөөц хөрөнгө/	9,455,907.00	-
Бусад төсөл арга хэмжээ	9,455,907.00	-
Бусад	9,455,907.00	-
Төсвийн хуваарилагдаагүй зардал	-	15,000,000.00
Бусад төсөл арга хэмжээ	-	15,000,000.00
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГА, НЭГЖҮҮДЭД ОЛГОСОН</b>	-	123,483.00
Төсвийн ерөнхийлөн захирагчдад олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	123,483.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	123,483.00
<b>НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ</b>	4,832,800.00	4,672,600.00
<b>Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж</b>	4,832,800.00	4,672,600.00
Мөнгөн хэлбэрээр	4,832,800.00	4,672,600.00
Нэг удаагийн тэтгэмж	4,832,800.00	4,372,600.00
Бусад	-	300,000.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	278,722,426.08	438,312,620.28
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	(262,261.08)	3,500,479.72
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>(262,261.08)</b>	<b>3,500,479.72</b>

#### Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Төгсгөлөөр/
		Эцсийн үлдэгдэл
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	261,697,200.00	422,401,100.00
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	261,697,200.00	422,401,100.00
Улсын төвлөрсөн төсвөөс	196,065,200.00	202,997,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	196,065,200.00	202,997,100.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	65,632,000.00	219,404,000.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	59,632,000.00	219,404,000.00
Хөрөнгийн	6,000,000.00	-
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	4,937,915.00	19,412,000.00
Бараа, үйлчилгээний борлуулалт	4,937,915.00	19,412,000.00
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	4,937,915.00	19,412,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	1,402,000.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	4,872,000.00	18,010,000.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	65,915.00	-

НАГ-АХ-/2013/-СА-02-38

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН		
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	266,635,115.00	441,813,100.00
<b>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</b>	115,282,371.00	129,017,639.00
Үндсэн болон нэмэгдэл цалин	103,803,398.00	116,143,055.00
Үндсэн цалин	86,413,498.00	96,518,755.00
Бусад нэмэгдлүүд	17,389,900.00	19,624,300.00
Үр дүнгийн урамшуулал	4,753,900.00	5,790,700.00
Унаа, болон бусад нөхөн олговор	12,636,000.00	13,833,600.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	11,478,973.00	12,874,584.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	9,556,913.00	10,532,384.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	7,827,100.00	8,188,884.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	559,100.00	585,900.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	830,450.00	1,171,700.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	340,263.00	585,900.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,922,060.00	2,342,200.00
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	139,304,282.00	294,124,783.00
Бараа үйлчилгээний урсгал зардал	35,328,240.00	26,317,383.00
Бусад бараа үйлчилгээний зардал	35,328,240.00	26,317,383.00
Бичиг хэргийн зардал	1,424,180.00	1,799,844.00
Тээвэр, шатахуун	6,120,540.00	7,200,000.00
Шуудан, харилцаа холбоо	3,529,698.00	3,998,471.00
Дотоод албан томилолт	400,000.00	466,000.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	330,700.00	500,000.00
Сургалт семинарын зардал	3,993,000.00	3,999,950.00
Жижиг эд хогшил худалдан авах	7,038,797.00	1,129,068.00
Багаж хэрэгсэл худалдан авах	7,038,797.00	195,490.00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	-	933,578.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	1,491,325.00	1,414,050.00
Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
Холбооны шугам ашигласны зардал	6,000,000.00	810,000.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	103,976,042.00	267,807,400.00
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	30,016,135.00	252,807,400.00
Соёл урлаг хөгжүүлэх зардал	-	222,809,250.00
Уран бүтээлийн зардал	29,950,220.00	29,998,150.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн зарцуулалт	65,915.00	-
Засгийн газрын нөөц хөрөнгө /Орон нутгийн нөөц хөрөнгө/	73,959,907.00	-
Бусад төсөл арга хэмжээ	73,959,907.00	-
Баяр наадмын зардал	64,504,000.00	-
Бусад	9,455,907.00	-
Төсвийн хуваарилагдаагүй зардал	-	15,000,000.00
Бусад төсөл арга хэмжээ	-	15,000,000.00
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГА, НЭГЖҮҮДЭД ОЛГОСОН</b>	-	123,483.00
Төсвийн ерөнхийлөн захирагчидад олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	123,483.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	123,483.00
<b>НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ</b>	4,698,800.00	4,684,600.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	4,698,800.00	4,684,600.00
Мөнгөн хэлбэрээр	4,698,800.00	4,684,600.00

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН		
Нэг удаагийн тэтгэмж	4,398,800.00	4,384,600.00
Бусад	300,000.00	300,000.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>259,285,453.00</b>	<b>427,950,505.00</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>7,349,662.00</b>	<b>13,862,595.00</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	7,537,000.00	13,665,845.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>7,537,000.00</b>	<b>13,665,845.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(7,537,000.00)</b>	<b>(13,665,845.00)</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(187,338.00)</b>	<b>196,750.00</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	187,338.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	196,750.00

#### Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2012 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	261,759,011.80	652,394.56	(179,221,172.34)	83,190,234.02
Тайлант үеийн үр дүн	-	-	3,500,479.72	3,500,479.72
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	61,759,011.80	652,394.56	(175,720,692.62)	86,690,713.74

#### Аудитлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	
			/+илүү, -дутуу/	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II+V)	202,997,400.00	202,873,617.00	(123,783.00)	-0.1
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (III+IV)	202,997,400.00	202,873,617.00	(123,783.00)	-0.1
III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	202,997,400.00	202,873,617.00	(123,783.00)	-0.1
Бараа ажил үйлчилгээний зардал	202,997,400.00	202,873,617.00	(123,783.00)	-0.1
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	129,029,000.00	129,017,639.00	(11,361.00)	0.0
Үндсэн цалин	102,311,300.00	102,309,455.00	(1,845.00)	0.0
Хоол унааны хөнгөлөлт	13,833,600.00	13,833,600.00	-	0.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,884,100.00	12,874,584.00	(9,516.00)	-0.1
Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэл	10,541,900.00	10,532,384.00	(9,516.00)	-0.1
Тэтгэврийн даатгал	8,198,400.00	8,188,884.00	(9,516.00)	-0.1
Тэтгэмжийн даатгал	585,900.00	585,900.00	-	0.0
ҮОМШ өвчний даатгал	1,171,700.00	1,171,700.00	-	0.0

НАГ-АХ-/2013/-СА-02-38

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН				
Ажилгүйдлын даатгал	585,900.00	585,900.00	-	0.0
Байгууллага төлөх ЭМД-ын хураамж	2,342,200.00	2,342,200.00	-	0.0
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	73,968,400.00	73,855,978.00	(112,422.00)	-0.2
Бичиг хэргийн материал	1,800,000.00	1,799,844.00	(156.00)	0.0
Тээвэр, шатахууны зардал	7,200,000.00	7,200,000.00	-	0.0
Шуудан холбооны зардал	4,000,000.00	3,998,471.00	(1,529.00)	0.0
Дотоод томилолтын зардал	468,400.00	466,000.00	(2,400.00)	-0.5
Ном , хэвлэлийн зардал	500,000.00	500,000.00	-	0.0
Сургалт семинарын зардал	4,000,000.00	3,999,950.00	(50.00)	0.0
Жижиг эд хогшил худалдан авах зардал	14,800,000.00	14,794,913.00	(5,087.00)	0.0
Төлбөр, хураамж, жижиг татварууд	1,500,000.00	1,414,050.00	(85,950.00)	-5.7
Урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00	-	0.0
Бусад зардал	30,000,000.00	29,998,150.00	(1,850.00)	0.0
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	4,700,000.00	4,684,600.00	(15,400.00)	-0.3
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	4,700,000.00	4,684,600.00	(15,400.00)	-0.3
<b>VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:</b>	<b>202,997,400.00</b>	<b>202,873,617.00</b>	<b>(123,783.00)</b>	<b>-0.1</b>
Төсвөөс санхүүжих	202,997,400.00	202,873,617.00	(123,783.00)	-0.1